



**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41, 32-09-16
И-мэйл: moh@moh.gov.mn, <http://www.mohs.mn>

2017.12.26 № 6/4870

танай _____-ны № _____-т

**АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ГАЗАР, ТӨРӨЛЖСӨН
МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛЭГ, ТУСГАЙ
МЭРГЭЖЛИЙН ТӨВ, ХУВИЙН ХЭВШЛИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН
ДАРГА, ЗАХИРАЛ НАРТ**

“Шинэ жилийн баярын үеэр эмнэлгийн тусламж, үйлчилгээг шуурхай, тасралтгүй хангаж ажиллах тухай” Эрүүл мэндийн сайдын албан даалгаврыг хүргүүлж байна.

Албан даалгаврыг хэрэгжүүлж, тайланг 2018 оны 01 дүгээр сарын 02-ны 17:00 цагаас өмнө Эмнэлгийн тусламжийн газарт ирүүлнэ үү.

ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖИЙН ГАЗРЫН
ДАРГА Я.БУЯНЖАРГАЛ



086548



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
АЛБАН ДААЛГАВАР

2017 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Шинэ жилийн баярын үеэр эмнэлгийн
тусламж, үйлчилгээг шуурхай, тасралтгүй
хангаж ажиллах тухай

Улсын хэмжээнд амбулаторийн үзлэгийн 6.2 хувийг томуу, томуу төст өвчин эзэлж, уг өвчнөөр өвчлөгсдийн 57.7%-ийг 4 хүртэлх насны хүүхдүүд эзэлж байгаа бөгөөд цаашид өвчлөл нэмэгдэх хандлагатайг тандалт судалгаа харуулж байна.

Иймд баярын өдрүүдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээг хурдан, шуурхай, тасралтгүй, чанартай үзүүлэх зорилгоор төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, тусгай эмнэлэг, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нар т ДААЛГАХ нь:

1. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнууд амралт, баярын өдрүүдэд гар утсаа 24 цагийн турш нээлттэй байлгах;
2. Амралт, баярын өдрүүдэд туршлагатай эмч, эмнэлгийн мэргэжилтнийг жижүүрт гаргах;
3. Хариуцлагатай жижүүр хийх, алсын дуудлаганд явах эмч, сувилагч, бусад мэргэжилтэн, туслах ажилтнуудын хуваарийг батлан, бэлэн байлгах;
4. Хөдөө орон нутагт амрах эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд тухайн газарт эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх гэнэтийн шаардлага гарсан тохиолдолд ажиллах боломжийг бүрдүүлэх;
5. Алсын болон ойрын түргэн тусламжийн дуудлаганд явах унааг бэлэн байлгах, шатахууныг хангалттай хэмжээгээр нөөцлөх;
6. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл болон эмнэлэг хооронд өвчтөн шилжүүлэх асуудлыг шуурхай зохион байгуулах;
7. Эрүүл мэндийн байгууллагууд хариуцлагатай жижүүрийн мэдээг Эрүүл мэндийн яамны хариуцлагатай жижүүрт тогтмол мэдээлэх Утас 323002;
8. Болзошгүй гамшиг, осол, хордлого, онцгой байдлын үед ажиллах, ор дэлгэх тооцоо, төлөвлөгөөг тодотгох, эмнэлгийн яаралтай тусламж, сэхээн амьдруулах эрчимт эмчилгээний тасаг нэгжийн ор, хүний нөөц, багаж тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж ажиллах;

080007

9. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, үйлчилгээний ажилтны анхаарал сулрах, хариуцлага алдах, ажлын байрыг орхиж явах, ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх зэрэг зөрчөл гаргахгүй байх, байнгын хяналт тавьж ажиллах;

10. Томуу, томуу төст өвчин, хоолны хордлого, осол гэмтлээс сэргийлсэн мэдээлэл сурталчилгааны ажлыг орон нутгийн хэвлэл мэдээллийг хэрэгслээр тогтмол түгээж, албан байгууллага, аж ахуй нэгжүүдэд өөрсдийн ажилтнуудаа эрсдлээс сэргийлсэн сэрэмжлүүлэг, зөвлөмж өгөхийг анхааруулах;

11. Албан даалгаврын хэрэгжилтийг 2018 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 17.00 цагаас өмнө Эмнэлгийн тусламжийн газарт ирүүлэх.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ